



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 10/7

Улаанбаатар хот

Байгууллагын ёс зүйн дэд хороог
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4 дэх хэсэг, Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны болон 03 дугаар сарын 26-ны өдрийн Хамт олны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн Ёс зүйн дэд хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Дарга	Хуулийн зөвлөх	Г.Бат-Отгон
Нарийн бичгийн дарга	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан	Э.Эрдэнэмаа
Гишүүд:	Нярав	Б.Отгонсайхан
	Захиргаа, хүний нөөцийн удирдлагын албаны дарга	Л.Жаргалсайхан
	Эрүүл мэндийн албаны эрхлэгч	Б.Алтангэрэл

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3.Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилласны урамшууллыг тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ